



БЛАН-ӨЛГИЙ АЙМАГ
ДЭЛҮҮН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/146

Рашаант

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 58 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэрээс сумын Засаг даргын тамгын газарт иргэн А.Санахын хашааны хойд талаас 400м² газрыг биеийн тамир спортын талбайн зориулалтаар, 9 дүгээр багийн нутаг дэвсгэрээс иргэн Ш.Шопаны хашааны залгаа газраас 400м² газрыг биеийн тамир спортын талбайн зориулалтаар тус тус 30 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Засаг даргын тамгын газартай газар эзэмшүүлэх гэрээ байгуулж гэрчилгээ олгохыг газрын даамал /Б.Берденбе/к-т зөвшөөрсүгэй.

3. Уг захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг багийн засаг дарга /Б.Бахытбек/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.СЕРИКБОЛ